



“сора интерэшнл” ххк

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨВСГӨЛ СУМ**

**“СОРГОВЬ” НҮҮРСНИЙ ИЛ УУРХАЙ**



**2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар : MV-020738

Аж ахуйн нэгжийн дугаар: РД:6232485

**ХЯНАСАН:**

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

БАЙГАЛИЙН НӨӨЦ УДИРДЛАНЫН

ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН .....

/

**ТАЙЛАГНАСАН:**

СОРА ИНТЕРНЭШНЛ ХХК-ИЙН ЗАХИРАЛ .....

/ Г.ГАНТУЛГА /

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН .....

/ Б.БАТБАЯР /

**2023 ОН**

**Агуулга**

<b>1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	4
<b>2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	4
2.1. Агаарын температур:.....	4
2.2. Хур тунадас:.....	5
2.3. Нарны цацраг, гийгүүлэлт: .....	5
2.4. Салхи, шуурганы горим:.....	6
2.5. Агаарын чийгшил ба даралт:.....	6
2.6. Төслийн бүснугийн физик-газар зүйн нөхцөл.....	6
2.7. Хөвсгөл сумын танилцуулга:.....	6
2.8. Хөрс ургамал .....	7
2.9. Амьтны аймаг.....	7
2.10. Ус зүй.....	8
<b>3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</b> .....	8
3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	8
3.2. Газрын гадарга болон газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	9
3.3. Гадаргын ус болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	9
3.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	9
3.5. Ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	10
3.6. Амьтаны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	10
3.7. Оршин суугчдад үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	10
<b>4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ</b> .....	11
4.1. Байгаль орчны бодлого.....	11
4.2. Байгаль орчны менежментийн зорилтууд: .....	11
4.3. Уулын ажлын товч танилцуулга .....	12
<b>5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ</b> .....	12
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .....	12
5.2. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	13
5.3. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах.....	14
<b>6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	15
<b>7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	17
<b>8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ, НӨХӨН ОЛГОВРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	25
<b>9. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	25
<b>10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	25
10.1. Химийн бодисын ашиглалт хэрэглээний сургалт.....	26
<b>11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ</b> .....	27
11.1. Зорилго.....	27

11.2.	Хог хаягдлын эх үүсвэрт тавигдах стандарт шаардлага .....	27
11.3.	ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	28
12.	БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	31
12.1.	Зорилго .....	31
12.2.	Агаарын чанарын хяналт .....	31
12.3.	Усан орчны хяналт .....	31
12.4.	Ургамлан бүрхэвчийн хяналт .....	31
12.5.	Хөрсөн бүрхэвчийн хяналт .....	36
13.	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	37
13.1.	Сургалт .....	37
13.1.1.	Сургалтын хуваарь .....	37
14.	ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ .....	40
15.	ХАВСРАЛТ .....	41

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Төсөл хэрэгжүүлэгч: “Сора Интернэшнл” ХХК,

Улсын бүртгэлийн дугаар: MV-020738

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Дорноговь аймаг Хөвсгөл сум Сорговь уурхай

“Сора Интернэшнл” ХХК нь 2019 оны 10-р сараас MV-020738 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нүүрс олборлох төслийг хэрэгжүүлэхээр бэлтгэл, бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж эхлэсэн.

Сорговь нүүрсний орд нь Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт оршино. Дорноговь аймаг нь нийт 109.5 мянган кв.км нутаг дэвсгэртэй бөгөөд хүн амын суурьшилт сийрэг буюу 1.6 квадрат километр нутагт 1 хүн, 5.7 квадрат километр нутагт 1 өрх ногдож байна. Тус ордын талбай нь Улаанбаатар хотоос зүүн урагшаа 650 км, Дорноговь аймгийн төв Сайншанд хотоос баруун урагшаа 200 км, Хөвсгөл сумын төвөөс баруун хойшоо 70 км, хилийн Ханги боомтоос 145 км-ийн зайд оршдог.



Зураг 1. Сорговь нүүрсний уурхайн төслийн байршил

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутаг дэвсгэр өвөл зуны температурын ялгаа ихтэй, хур тунадас багатай халуун зунтай, хуурайвтар уур амьсгалын мужид, зөөлөвтөр өвөлтэй дэд мужид хамаардаг. Агаарын үнэмлэхүй их температур +41°C-ээс давж халах үнэмлэхүй бага температур – 40°C-ээс хүйтэн болох тохиолдол байдаг.

### 2.1. Агаарын температур:

Хөвсгөл сумын хувьд цаг уур нь харьцангуй дулаан, хүйтний улирал 11-р сарын 2-оос эхэлж 3-р сарын 25 хүртэл 143 хоног, дулааны улирал 3-р сарын 25-аас 11-н сарын 2 хүртэл 222 үргэлжилдэг байна. Төсөл хэрэгжиж буй газар харьцангуй нам дор, өргөн уудам хөндий

бөгөөд говийн нам толгод гүвээгээр хүрээлэгдсэн газар бөгөөд жилийн ихэнх өдрийн температурын дундаж нь “+” градустай байдаг. Агаарын дундаж температур зуны улиралд 20-24.00С, өвлийн улиралд -11.7-15.90С байдаг. Жилийн дундаж температур нь +3.70С байдаг.

Хөрсний гадарга дээр зундаа +59.00С хүртэл халж, өвөлдөө-36.60С хүртэл хүйтэрдэг. Газрын гүнд температурын хуваарилалт нь тодорхой зүй тогтолтой. Зуны улиралд гүн ихсэхээр температур буурч, өвлийн улиралд гүн рүүгээ дулаарч хавар намар шилжилтийн байдалтай байдаг. Хөрсний гэсэлт нар дулааны нэвчилт нөлөө үйлчлэлтэйгээр газрын өнгөн хөрснөөс алгуур гэсэж газрын гүн рүү аажим доошилж дуусдаг.



Зураг 2. Сорговь төслийн талбайн газрын гадаргын температур

## 2.2. Хур тунадас:

Хөвсгөл сум орчимд хур тунадасны хэмжээ бага, хуурай цаг агаартай. Жилдээ орох хур тунадасны хэмжээ нь дөнгөж 102.4 мм бөгөөд хур тунадасны 60% нь зуны улиралд ордог ба зундаа тоотой их усархаг түр зуурын бороо ордог. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын дулаарлаас шалтгаалан зүсрэн орох бороо цөөрч ганц нэг хүчтэй аадар бороо орох болсон. Өвөлдөө цас маш бага унадаг бөгөөд цасан бүрхүүл бараг тогтдоггүй. Жилийн ойролцоогоор 30 хоногт л бороо ордог байна.

## 2.3. Нарны цацраг, гийгүүлэлт:

Манай орны нутгаар жилд дунджаар нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа 2800-3600 цэгийн хооронд хэлбэлзэж байдаг ба нийлбэр цацрагийн хэмжээ жилд 5237.5-6285 мДж/м<sup>2</sup> байдаг. Хөвсгөл сум орчмын нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа дунджаар жилд 3409.1 цаг, сард 284.1 цаг, хоногт 9.45 цаг байдаг.

#### 2.4. Салхи, шуурганы горим:

Говийн бүсэд голдуу баруун хойноос харьцангуй хүчтэй салхилдаг. Жилийн дундаж салхины хурд 3.7 м/с, сүүлийн 10 жилд салхины хурд хамгийн ихдээ 30 м/с хүрч ширүүсч байсан байна. Төслийн бүс нутагт жилийн дундаж байдлаар баруун, баруун хойд чиглэлийн салхи зонхилно. Өвлийн улиралд баруун, баруун хойд, хойд чиглэлийн салхи зонхилж байснаа зуны улиралд өмнөд зүгийн салхины давтагдал нэмэгдэж ирдэг зүй тогтолтой.

#### 2.5. Агаарын чийгшил ба даралт:

Хөвсгөл сумын нутаг дэвсгэр нь чийгшил багатай хуурай уур амьсгалтай нутаг бөгөөд агаарын харьцангуй чийгшлийн дундаж утга 45-50%, их утга өвлийн улиралд ажиглагдах бөгөөд 1 ба 12 саруудад 50-68%-тай байна. Хавар намарт агаарын харьцангуй чийгшлийн бага утга буюу 22-47% ажиглагдана. Хоногийн явцад агаарын харьцангуй чийгшлийн их утга өглөө үүрээр, бага утга нь их үдэд ажиглагддаг. Агаарын даралт дунджаар 847-856гПа, өвлийн агаарын дундаж даралт 856гПа, зуны агаарын дундаж даралт 847гПа байдаг.

#### 2.6. Төслийн бүснугийн физик-газар зүйн нөхцөл

Дорноговь аймгийн Хөвсгөл сум нь Монгол орны физик газарзүйн мужлалаар газрын гадаргын хувьд Говийн-Их мужид багтдаг. Төслийн нутаг дэвсгэрт Эхэн хайлааст уул (1873 м), Дэнгийн нуруу (1975 м), Дөрвөлжин уул (1612м)-с орших бөгөөд талбайн ойролцоох уулс толгод нь д.т.дээш 1600-1900 м, мөн Гурвантэс-Борзонгийн говийн элсний мужид хамаарагдах Жарангийн элс байрлана.

Төслийн талбай нь Эхэн Хайлаастын синклиналийн баруун хойт хэсэгт байрших ба нүүрсний давхраас агуулагч дээд пермийн Дэлийн шанд формацын хурдас нь хойт хэсгээрээ дунд-дээд карбоны Тост формацын андезит-базальтаас тогтох эффузив зузаалаг болон түүнийг зарим хэсгээрээ тасалдалтайгаар хучих доод пермийн Тогоот хар формацын риолит, риодацитаас тогтох хүчиллэг зузаалаг дээр угаагдлын гадаргуугаар хиллэдэг болно. Дэлийн шанд формац хайгуулын талбайн энэ хэсэгт бараг бүхэлдээ дээд дөрөвдөгч-орчин үеийн сэвсгэр хурдсаар хучигдах боловч гуу жалгаар хэрчигдэж идэгдсэн хэсгийн хоёр захаар байнга ил гардаг гаршийн уналын азимут нь 170-2000, налуугийн өнцөг нь 35-400 байна.

#### 2.7. Хөвсгөл сумын танилцуулга:


Дорноговь аймгийн Хөвсгөл сум нь аймгийн төв Сайншандаас 160 км-т, Улаанбаатар нийслэлээс 624 км-т байрладаг. 8400 кв/км нутагтай. Хөвсгөл сум нь Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошууны нутаг бөгөөд Ардын хувьсгал мандсаны дараа 1924 онд Хутаг уулын хошууны Цээл сум, Ойдог зангийн сум, 1925 онд Өлзийт, 1929 онд Жавхлант, 1931 онд Гурван Хөвгөл уулын энгэрт төвлөрч Хөвсгөл сум болжээ.

Одоо тус сум Гурван хөвсгөл, Жавхлант, Элст, Чулуут гэсэн 4 багтай, 1593 хүн амтай, төвийн эрчим хүчинд холбогдсон, үүрэн телефоны үйлчилгээтэй, 240 хүүхдийн суудалтай ЕБСургуультай, 50 ортой дотуур байр, 10 ортой хүн эмнэлэг, 75 ортой хүүхдийн цэцэрлэг, 160 хүний суудалтай соёлын төв ажиллаж байна.

Хөвсгөл сум нь байгалийн үзэсгэлэнт газар олонтой бөгөөд үүнд нутагт Хутаг уул, Гуа тээг, Сүлдэнэ хөх овоо, Шувуун шанд, Харанхуйн ам, Асман булаг, Эхэнэ улаан худаг зэрэг байгалийн үзэсгэлэнгээ гайхуулсан газар нутагтайн зэрэгцээ байгалийн төрөл бүрийн эмийн ургамал элбэгтэй ба ан амьтан араатан жигүүртнээр элбэг.

## 2.8. Хөрс ургамал

Говийн хөрсний их мужийн цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг. Хур тунадас ховор, эрс гандуу уур амьсгалтай, өвс ургамал тарчиг сийрэг энэ талбай нь говийн бор хөрстэй. Хөрс үүсэх явц гандуу нөхцөлд явагдах учир салхины үйл ажиллагаа хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж, ууршилтыг ихэсгэн хуурайшихад нөлөөлж өвс ургамлыг хийсгэн тараах тул зөвхөн үндэсний зарим нь ялзмаг болдгоос органик үлдэгдлийн хэмжээ маш бага 1% -иас бараг үл хэтэрнэ. Иймээс сайр чулуу ихтэй хуурай хагас карбонатлаг байдгаас нийтлэг мараалаг шинж үл ажиглагдана. Харин хонхор, хотгор, тойром, булаг шанд бүхий газруудаар хужир мараа энд тэнд тогтсон байна. Говийн цаг уур, хөрсний онцлогоос шалтгаалан ургамлын нягтшил багатай, сийрэг тачир хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, шарилж, таана, мангир, хөмөл, монгол өвс, хазаар өвс, баглуур зэрэг олон наст ургамал, чихэр өвс, цулхир, гоёо зэрэг эмийн ургамал, хайлаас, тоорой, сухай, заг, жигд, зэгс, зээргэнэ, бударгана, хармаг, харгана гэх мэтийн модлог, бутлаг говь цөлийн ургамал ургадаг.




Зураг 2. Сорговь төлийн талбайн ургамлын бүрхэвч

## 2.9. Амьтны аймаг

Энд говь цөлийн амьтад болох хулан, аргаль, янгир, хар сүүлт зэрэг туурайтан, махчин амьтдаас чоно, шилүүс, хярс, үнэг, өмхий хүрэн, мануул, жигүүртнээс бүргэд, тас, шонхор, харцага, элээ, ногтруу, тагтаа, болжмор, хулан жороо, хэвлээр явагчдаас олон зүйл гүрвэл, могой, мэрэгчдээс туулай, алаг даага, чичүүл, бозлог, шавьж идэштнээс зараа, шавьжаас хэдэн төрлийн аалз, арваалж, ямаан ууц, байх ба эдгээр амьтдаас нэн ховордсон, устаж алга болохын даваан дээр байгаа төрөл, зүйлүүдийг агнах, устгахыг хориглож дархан цаазтай болгожээ.

## 2.10. Ус зүй

Дадын хар толгой-2 талбай нь төв Азийн гадагшаа урсгалгүй ай савын бүсэд багтдаг. Талбайн хэмжээнд гадаргуугийн усан сүлжээ муу хөгжсөн ба байнгын урсгал ус байдаггүй. Талбайн хэмжээнд жижиг булгууд байх боловч эдгээр нь тухайн жил улирлын цаг уур, хур тунадасын хэмжээнээс хамаарч усны горим хувьсамтгай зарим үед гандаж ширгэдэг. Хуурай сайр, тойрмууд нь хур тунадас ихтэй үед усаар дүүрээд богино хугацаанд хөрс болон агаарт ууршдаг. Хүн малын усны хэрэгцээнд голлон худгийн ус хэрэглэх ба багаар булаг шандын ус ашигладаг. Залуу хагарлууд дагасан дөрөвдөгчийн хурдсанд хуурай сайр нуурын зах хавий бараадуулан гар болон өрөмдмөл гүний худгууд гаргасан байдаг бөгөөд эдгээрийн усны түвшин 1-7 м хүртэл гүнтэй, эрдэсжилт ихтэй байна.



Зураг 3. Галба-Долоодын говийн сав газар байрлах Сорговь төслийн байршил

## 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

### 3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

“Сора Интернэйшнл” ХХК-ийн “Сорговь” нүүрсний уурхайн үйл ажиллагааны явцад төслийн орчны агаарт халаалтын зуух, хүнд механизмуудаас агаарт бохир утаа хаягдах, бохирдуулагч хорт хий үүсч агаар бохирдуулах нөлөөлөл үзүүлж болзошгүй. Үүний зэрэгцээ төслийн талбайн орчмын нутаг нь уур амьсгалын хувьд хэт хуурай, жилдээ хур тунадас маш бага унадаг говь цөлийн бүсэд оршдог. Хур бороо багатай агаар хуурайшсан салхитай үед хөрсний овоолго, уурхайн мөргөцөг ба ажлын түвшин, уурхайн дотоод зам зэргээс тоос шороо хийсэх, мөн тэсэлгээний үед их хэмжээний тоос босдог нь ажиллагсадын эрүүл мэнд, орчны агаар, хөрс ургамлын бүрхүүлд нөлөөлнө. Цаг агаар, салхины хурд, газарзүйн онцлог, тээврийн хэрэгслийн төрөл, жин, хурд, нэгж тээвэрлэлтийн хугацаа зэргээс шалтгаалан нөлөөлөл нь ялгаатай байна.



### **3.2. Газрын гадарга болон газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Нүүрсний ордоос нүүрс олборлохын тулд хийгдэх уурхайн бүтээн байгуулалт, уурхайн үйл ажиллагаа, болон нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааны явцад хөрс хуулах, уурхайн дотоод зам дэд бүтцийн барилга байгууламжууд зэргээс газрын гадаргад тодорхой өөрчлөлтүүд гарна. Газрын байгалийн өнгө төрх, геологийн тогтоц шууд өөрчлөгдөх зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Түр хугацаагаар ашиглах барилга, байгууламж байршуулах газруудад шимт хөрсийг хуулж хадгалж байгаад ашиглалтын дараа хаалтын нөхөн сэргээлтээр хэлбэршүүлэн тэгшилж, шимт хөрсөөр хучин ургамалжуулах тул ийм төрлийн эвдрэлтэй газруудад газар дүрсийн өөрчлөлт орохооргүй байдал ажиглагдаж байна. Үйл ажиллагаанд өртөх талбайн дийлэнхийг Гөлөөний тойрмын шал хэсэг эзэлдэг. Газар болон газрын хэвлийд үзүүлэх нөлөөллийн эрчим нь үйл ажиллагааны үргэлжлэх хугацаанаас хамаарч байгаа тул ашиглалтын богино хугацаатай төслийн хувьд газар дүрсийн өөрчлөлтөөс бусад сөрөг нөлөөг бууруулах, улмаар арилгах боломжтой болно.

### **3.3. Гадаргын ус болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Төсөл хэрэгжих нутаг нь Төв Азийн гадагш урсацгүй ай савын гадаргын усны нөөц багатай нутагт багтах бөгөөд цөл, цөлөрхөг хээр, хээрийн бүс хосолсон халуун хуурай бүс нутагт хамаарах ба бүс нутгийн гадаргын усны хамгийн гол сүлжээ нь Цувираагийн сайр ба Гөлөөний тойром байна. Энд байнгын урсацтай гол горхи байхгүй бөгөөд зөвхөн эрчимшил ихтэй бороо, хайлсан цаснаас хуурай сайруудаар түр урсац үүсэх нөхцөлтэй. Түр урсац нь жижиг нуур, тойрмуудыг мөн түр устай болгож удалгүй ууршлын улмаас хатаж ширгэнэ. Түр урсацтай сайрууд болон нуур тойром намгууд нь тодорхой хэмжээгээр ууршиж, газарт шингэж алга болох хүртэл тодорхой хугацаанд хүн, мал, зэрлэг амьтны унд болдог байна.

Төслийн талбай Цувираагийн сайр цутгах Гөлөөний тойромд байрших тул хур тунадас их үед үерт өртөх усанд автах магадлалтай. Иймээс төслийн үйл ажиллагаанаас гадаргын усанд дараах нөлөөллийг үзүүлж болзошгүй.

Их борооны үед уурхайг усанд автуулах, овоолгын суурийг идэх зэрэг төслийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй учир Цувираагийн сайраас орж ирэх урсацыг хөрсний овоолго болон хамгаалалтын далангаар чиглэл барин даялуулан өөрчлөх бөгөөд энэ нь урцасын горимыг өөрчлөлтөд оруулна. Горимыг өөрчлөх боловч усны хуримтлал Гөлөөний тойрмоос гадагш гарахгүй.

Төсөл хэрэгжүүлэхэд усыг унд ахуйн хэрэгцээ болон технологийн хэрэгцээнд ашиглана.

Уурхайн орчмын гүний худгийн усны нөөц, усны чанарт нөлөөлөх нөлөө бага, ойр орчмын худгийн усан дахь цацраг идэвхит изотопын хувийн идэвх нэмэгдэхгүй. Төслийн үйл ажиллагааны явцад газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна.

### **3.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Говийн хөрсний их мужийн цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг. Хур тунадас ховор, эрс тэс гандуу уур амьсгалтай, өвс ургамал тарчиг сийрэг энэ талбай нь говийн бор хөрстэй. Ашиглалтын явцад нийт 218,3 га талбайн хөрсөн бүрхэвч эвдэрч доройтохоор байгаа бөгөөд шалархуу төрлийн хөрс хамгийн их орон зайг эзэлж байна.

Нүүрс олборлолтод өртөгдөх дийлэнх талбай Гөлөөний тойрмын шалархуу хөрстэй газарт явагдах бөгөөд ургамлан нөмрөггүй тухайн газрын хөрсний эвдрэлийн цар хүрээ улам нэмэгдэх.

Салхи шуургатай үед шимт хөрс болон хурдас чулуулгийн овоолгууд болон шинээр үүссэн шороон замын нөлөөгөөр хөрсний бүтэц алдагдаж нарийн ширхэгтэй тоос, шороо агаарт дэгдэж, орчны газрын хөрс, ургамлан нөмрөгийг доройтуулах

Ашиглалтын явцад үүсэх уурхайн карьер, шимт хөрсний болон хурдас чулуулгийн овоолгууд нь сөрөг нөлөөллийн их зэрэглэлд хамрагдах бөгөөд ялангуяа ашиглалтын талбайд байрлалтай ухагдсан далан шуудуу ил уурхай-нүүрсний агуулах хурдас чулуулгийн овоолго хооронд үүссэн замын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч их хэмжээгээр доройтож эвдрэхээр байна.

### **3.5. Ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Төслийн хэрэгжилтийн явцад, ялангуяа шимт хөрсийг хуулах үед ургамал, ургамлан нөмрөг биет хэмжээгээр сүйтгэгдэж дараах төрлийн сөрөг нөлөө үүсэж болзошгүй. Үүнд:

- Хуулсан шимт хөрстэй хамт ургамлын үрийн болон ургал эрхтэний нөөц зөөвөрлөгдөж, шимт хөрсийг буруу хадгалбал тэдгээр нөөцүүд шууд эрсдэлд орно.
- Уул уурхай үйл ажиллагаа хязгаарлагдмал, бага хэмжээний орон зайд, богино хугацаанд явагдах тул ургамлын зүйл, төрөл устах аюул нүүрлэхгүй.
- Уурхай болон овоолгууд, нүүрс хадгалах агуулахаас салхитай үед тоос, тоосонцорууд хийсэж эвдрэлд өртөөгүй газрын ургамал, бэлчээрийг дарах сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

### **3.6. Амьтаны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

“Сора Интернэйшнл” ХХК-ийн “Сорговь” нүүрсний уурхайн үйл ажиллагаа болон нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааны явцад амьтаны аймагт дараах нөлөөллүүд үүсч болзошгүй юм.

- Энэ бүс нутгийн махчин амьтад нь ихэвчлэн шөнийн идэвхтэй тул өдрийн цагаар махчин амьтдад үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага ба хулан гэх мэт зүйл хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн талбайгаас зайлсхийх магадлалтай.
- Мах идэшт хөхтөн амьтад нь байнгын хөдөлгөөний ачаалалтай автозамуудыг хөндлөн гарахаас зайлсхийх, уурхайн байнгын ажилагааны явцад дуу чимээ, хөдөлгөөнөөс зайлсхийх хандлагатай бөгөөд энэ нь популяцийн тусгаарлалт үүсгэх сөрөг нөлөөтэй.
- Уурхайн байнгын ажиллагаа болон нүүрс тээвэрлэх ажил гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн байнгын шилжилт хөдөлгөөн, дуу чимээ нэмэгдсэнээр ан амьтан дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьдрах орон зай нь хумигдана.

### **3.7. Оршин суугчдад үзүүлэх сөрөг нөлөөлөл**

“Сора Интернэйшнл” ХХК-ийн “Сорговь” нүүрсний уурхайн талбай орчимд байнгын суурьшилтай малчин өрхүүд нь тусгай зөвшөөрлийн хилийн гадна байх бөгөөд төслийн талбайгаас хамгийн багадаа 3.5 км алслагдсан байршилтай байх нь газар чөлөөлөх шаардлагагүй болохыг харуулж, өрхүүдийн байршилд төслөөс үзүүлэх нөлөө үгүй болохыг илтгэнэ. (БОННУ)

Малчин өрхүүд тус бүртээ эзэмшлийн худагтай бөгөөд худаг уст цэг өвөлжөө, хаваржааны бууцнаас 500-3500 орчим метрийн зайд байдаг ба худгийн усаар малаа услахаас гадна унд ахуйдаа хэрэглэдэг бөгөөд төсөл хэрэгжих газрын эргэн тойронд нийт 8 худаг, уст цэг бүртгэснээс 5 нь байнгын устай байдаг ч малчдын үзэж байгаагаар энэ нь бэлчээрийн усан хангамжийг бүрэн хангаж чаддаггүй байна. (БОННУ) Мөн хүн амын тоо, бодит орлого

нэмэгдэх, үйлдвэр үйлчилгээний салбарын үйл ажиллагааг нэмэгдүүлэх г.м) эерэг нөлөөлөхөөр байна.

## **4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ**

### **4.1. Байгаль орчны бодлого**

Байгууллагын зорилго болон төлөв байдал, үйл ажиллагаа явуулж байгаа хүрээлэн буй орчны нөхцөл байдлыг анхааран авч үзсэнээр Сора Интернэшнл ХХК-ийн удирдлагууд нь нийцлийн үүргийнхээ дагуу ISO 14001:2015 стандартын зарчим болон шаардлагуудыг даган мөрдөж Байгаль орчин (БО)-ны удирдлага тогтолцоог байнга сайжруулж хэрэгжүүлнэ.

Бид хүрээлэн буй орчны бохирдлоос урьдчилан сэргийлж, гарах сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно. Үүнд:

- Компанийн дээд удирдлагаас эхлэн бүх шатны удирдах ажилтнууд Хүрээлэн буй орчны асуудлаар манлайлагч нь байж, удирдах ажилтны үүрэг хариуцлагыг бүрэн ухамсарлана.
- Хүрээлэн буй орчны доройтлоос урьдчилан сэргийлж, сөрөг нөлөөлөл учруулахгүйн тулд Байгаль орчны журмуудыг даган мөрдөнө.
- Байгалийн нөөцийг зөв зохистой ашиглах, удирдлагын тогтолцоог байнга сайжруулах үйл ажиллагаандаа нийт ажиллагсад, харилцагч байгууллагуудын оролцоог хангана.
- Нийт ажилчдад Хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлж ажиллах мэдлэг, ойлголтыг олгож, тэднийг зөв арга барилд сургаж ажиллана.
- Хүрээлэн буй орчинд бага нөлөө үзүүлдэг шинэ материал бүтээгдэхүүнийг шинжлэн судлаж аюултай хог хаягдлын үйл явцыг удирдаж сайжруулна.
- Эрхэлж буй үйл ажиллагаандаа нөхөн сэргээгдэхгүй эрчим хүчний хэрэглээг бууруулж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр оруулах технологийг нутагшуулахыг эрмэлзэнэ.
- Хүрээлэн буй орчинд үзүүлэх үр нөлөөг сайжруулахын тулд жил тутам удирдлагын дүн шинжилгээ хийж, үр дүнг нийт ажиллагсад, сонирхогч талуудад мэдээлнэ.

### **4.2. Байгаль орчны менежментийн зорилтууд:**

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Сорговь нүүрсний орд газрын ил уурхайн үйл ажиллагааны явцад “Сора Интернэшнл” ХХК болон түүний гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилготой. “Сора Интернэшнл” ХХК ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд уурхайлалтын үйл ажиллагаанд оролцож буй нийт ААН, үйлдвэрлэл эрхлэгчдэд тус БОМТ-г мөрдүүлнэ.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорьсон. Үүнд:

- Монгол улсын холбогдох хууль тогтоомж стандартууд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хариуцлагатай уул уурхайн тэргүүн туршлагуудыг хэрэгжүүлж ажиллах ба нийтээр дагаж мөрдөх байгаль орчны бодлого, хууль, тогтоомжид нийцүүлэн төслийн бүх үйл ажиллагааг явуулах
- БОННҮнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,
- Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох,
- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах эд материалыг зүй зохистой ашиглан, байгалийн нөөц баялгийг арвилан хэмнэх зарчмыг баримтлан ажиллах.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө түүний гүйцэтгэлийг байнга сайжруулахын тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж үйл ажиллагааныхаа удирдлага зохион байгуулалтад хяналт тавьж, үнэлж дүгнэ ажиллах.


### 4.3. Уулын ажлын товч танилцуулга

“Сорговь” нүүрсний ил уурхай нь 2019 оны 9 сараас эхлэж үйл ажиллагаагаа эхлэсэн бөгөөд 2023 оны 10-р сарын 28-ны байдлаар нийт 25,056,099м<sup>3</sup> уулын цул ухаж ачсан байна.

Уулын ажлын төлөвлөгөө нь нийт 16.6сая.м<sup>3</sup> бөгөөд хөрсний гүйцэтгэл 29%-тай, нийт уулын цулын гүйцэтгэл 30%-тай, нүүрсний гүйцэтгэл 42%-тай. Уурхайн нийт шимт хөрсний хэмжээ 538,193м<sup>3</sup> байна.

Хүснэгт 1.

№	Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1.	Хөрсний хэмжээ	м <sup>3</sup>	15,920,309	4,923,495	29%
2.	Нүүрс	тн	1,000,000	417,405.9	42%
3.	Нийт уулын цул	м <sup>3</sup>	16,085,993	5,210,123	32%



## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Агаарын чанар, хөрс, усан орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

### 5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хүснэгт 2.

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Биелэлт
1.	Орчны тоосжилтыг бууруулах зорилготой зам дагуух усалгаа хийх	Орчны тоосжилтыг багасгах зорилгоор технологийн зам, талбайд тогтмол усалгаа хийгдэж хурдны хязгаарт хяналт тавина.	Өдрийн усны дундаж зарцуулалт 150м <sup>3</sup> - ихгүй	Өдөр тутамд зам талбайн тоос дарах зорилгоор усалгааг тогтмол хийлгэж байна.
2.	Автомашин хурдны хязгаарт хяналт тавих	Автомашин хурдны хязгаарын хэмжиж бүртгэл мэдээлэл хөтлөх	7 хоногт 3-4 удаа	Хурд хэмжигч багаж ашиглан Автомашин хурдны хязгааралт тавьж ажиллаж байна.

Зураг 1. /Зам усалгаа/



Зураг 2. /Автомашины хурдны хязгаар/



**5.2. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт**

Хүснэгт 3.

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Биелэлт
1.	Олон салаа зам гарган хөрс эвдрэхээс урьдчилан сэргийлэх	Төслийн талбай доторх замыг тэмдэгжүүлэх, холбогдох дүрэм журмыг мөрдүүлэх, зам ашиглалтыг хянах, арчилгааг тогтмол хийх	Тусгай зөвшөөрлийн талбайн хил	Олон салаа зам гаргахаас сэргийлэн уурхай орчимд нэг маршрутын зассан зам ашиглаж тэмдэглэгээ байршуулан тогтмол арчилгаа хийж ашигладаг.
2.	Уурхайн нөлөөллийн бүсийн хөрсөн бүрхэвчээс дээж авч Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлэх	Инженер геодези ХХК-д Засварын талбай, Шимт хөрсний овоолго, үйл ажиллагааны нөлөөллөлд өртсөн талбайгаас дээж авч хөрсний механик бүрэлдэхүүн, хүнд металлыг тодорхойлуулах	Тусгай зөвшөөрлийн талбайд	Улирал дутамд нэг удаа дээж авч шинжилгээнд хамруулаж байна.
3.	Газар шорооны ажлын үед шимт хөрсийг стандартын дагуу хуулах	Шимт хөрсийг стандартын дагуу хуулж тусгай овоолго үүсгэж хадаглана	м3	Шимт хөрс хуулах газар хөндөх ажлыг компаний дотоод журам болон MNS 5916:2008 стандартыг мөрдлөг ажилладаг. Шимт хөрс хуулах, газар хөндөх зөвшөөрөл нийт 9 удаа зөвшөөрлийн маягтын дагуу авсан. 2023 онд нийт


				538,193.6м3 шимт хөрсийг хуулж тусгай талбайд буулган овоолго хадгалсан.
4.	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Зөвшөөрөлгүй газар хөндсөн тохиолдолд байгаль орчны зөрчлөөр бүртгэж, зөрчлийг арилгах шаардлагатай арга хэмжээг авах	Зөрчил илэрсэн тохиолдол бүр	Шимт хөрс хуулах, газар хөндөх удирдлагын компаний дотоод журмын дагуу газар хөндөх зөвшөөрлийг олгож газар шорооны ажил хийлгэж бүртгэл хөтөлдөг. Нийт 9 удаа зөвшөөрөл өгч журмын дагуу ажил гүйцэтгүүлсэн.

### 5.3. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах

Хүснэгт 4.

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Биелэлт
1.	Ахуйн бохир усыг байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр хангаж ажиллах	Хаягдал ус зайлуулах цэг тогтоосон зөвлөмжийн дагуу бохир усыг зөөвөрлөн хаях сан байгуулах, улиралд тутамд шинжилгээнд хамруулах	1	Ханлаб лабораторид бохир усны шинжилгээнд хамруулсан
2.	Ундны усны эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах	Ундны усны эрүүл ахуйн хамгаалах бүсийн тэмдэг тэмдэглэгээ байршуулах, сар бүр тогтмол цэвэрлэгээ хийх		Эрүүл ахиун бүст анхааруулах самбар байршуулсан тогтмол цэвэрлэгээ хийдэг.
3.	Усны хэрэглээг хамгийн бага түвшинд барих	Ус, усны хэрэглээний тухай нийт ажилчдад сургалт орох	1	
4.	Усны хэрэглээг хамгийн бага түвшинд барих	Ус, усны хэрэглээний тухай нийт ажилчдад сургалт орох	Тодорхойлох боломжгүй	Дэлхийн усны өдөр 03-р сарын 22-нд нийт ажилчдад усны тухай танилцуулга хийсэн. Угаалгын өрөө дүш зэрэгт усыг ариг гамтай хэрэглэх санамж, зөвлөмж байршуулсан.
5.	Худгийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх	Журмын дагуу эрүүл ахуйн бүс тогтоож хамгаалалтанд авах	50м <sup>2</sup>	Ашиглалтын 1 худагтай худгийн эрүүл ахуйн бүсийг хамгаалан шороогоор....м3 талбайд далан үүсгэж тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан. Мөн байнгын харуул хамгаалалтын хяналтанд байлгадаг.

График 1. /Ус ашиглалт/



## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5.

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Биелэлт
1.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 2100 ширхэг модны суулгацыг тариалах, өнгөрсөн жил тарьсан модны усалгаа арчилгаа хийж ургалтыг нэмэгдүүлэх	Намрын улиралд 2100 ширхэг модыг тус бүр тарьж ургуулах усалгаа арчилгаа тогтмол хийж гүйцэтгэнэ.	2100 ш	Дорноговь аймгийн Хөвсгөл сумын төв зам дагуу намрын мод тариалалт 1 га талбайд Хайлаас модны тариалалт хийгдсэн Мөн тариалалт хийсэн талбайгаа 1400 м хашаажуулж өгсөн.
2.	Дорноговь аймгийн БОАЖГ-аас энэ оны БОМТ-д заган ойг нөхөн сэргээх тал дээр анхаарч ажиллах чиглэл болгосон.	Заган ойн экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй тал дээр анхаарч ажиллах	200 ш	Уурхай орчны нөлөөллийн бүсийн заган ойг нэмэгдүүлэх, хамгаалахын хүрээнд 0.2 га талбайд суулгац тариалж усалгаа арчилгаа хийж гүйцэтгэсэн.



Зураг 7. /Заган ойг нөхөн сэргээлт /





## 7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

“Сора Интернэшнл” ХХК нь уурхайн бүтээн байгуулалтын явцад төслийн талбайн орчны бүс нутгийн биологийн төрөл зүйлд тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл үүсэхгүй бөгөөд, Бид биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө хэрэгжүүлэхэд доорхи зарчмыг баримтлан жил бүрийн Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тодорхой ажлуудыг тусган ажиллаж байна. Үүнд:

- Төслийн талбай, хүрээлэн байгаа орчны биологийн төрөл зүйлд аль болох нөлөө үзүүлэхгүй байх буюу бага байлгах зорилгоор нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, хянах тохирох арга техник, журмыг хэрэгжүүлэх.
- Ажлыг гүйцэтгэхдээ экологийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлөхгүй, амьд байгалын хөдөлгөөнд үзүүлэх нөлөөллийг Төслийн баримт бичигт заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга барилаар ажиллах.
- Амьтан, ургамалд ноцтой нөлөөлөл/гэмтэл учруулах тохиолдлыг мэдээлэх.

### Хүснэгт 6.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Арга хэмжээний цар, хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Биелэлт
1.	Биотехникийн арга хэмжээ	Идэш тэжээл хомсдсон усгүйтсэн бэлчээр нутагт	Сумын БО мэргэжилтэнтэй хамтран хийх	1	Өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2 цэгт өвс байршуулсан
2.	Биотехникийн арга хэмжээ	усгүйтсэн бэлчээр нутагт	Уст цэг байгуулах	2	Уурхайн хэмжээнд ан амьтадад зориулсан цөөрөм 2 байгуулж 7 хоногтоо 1 усны машинаар ус хийж дүүргэдэг
3.	Биотехникийн арга хэмжээ	Мэдрэгчтэй худгийн усны онгоцыг засаж янзлах	Усны онгоц солих	1	Мэдрэгчтэй худгийн усны онгоцыг засаж сольж суурилуулалт хийж гүйцэтгэсэн

Зураг 10. /Ан амьтдад зориулсан худаг/





Зураг 12. /Биотехнологийн арга хэмжээ/



Зураг13./Мэдрэгчтэй худгийн усны онгоцыг засаж сольсон/



Зураг 12./Хөв цөөрөм байгуулсан/



## АН АМЬТАДЫН СУДАЛГАА

### 1.Үндэслэл

Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр ан амьтадын амьдрах орчин өөрчлөгдөж ан амьтадын тоо толгой буурах, дайжих, экологийн тэнцвэртэй байдал алдагдаг зэрэг сөрөг нөлөөтэй. Иймд төсөл хэрэгжиж буй газар нутгийн ан амьтадыг тогтмол судалж, түүнд зориулсан ажил хэрэг төлөвлөж хэрэгжүүлэх, сөрөг нөлөөллийг бууруулах хайрлан хамгаалах, олон нийтэд ан амьтадын талаарх танин мэдэхүйг дээшлүүлэх

### 2.Арга зүй

БОАЖЯ, МУШУА Биологийн хүрээлэн. /2021 Амьтан, Ургамлын мониторинг судалгааны түгээмэл аргууд. Улаанбаатар/ Ашиглан амьтадын судалгаа хийсэн.

### **3.Хээрийн судалгаа**

2023 оны 09 сарын 05 өдөр төслийн талбайн зүүн, баруун урд зүгүүдэд нийт 54 км явж ойр орчмын ан амьтадын судалгаа хийсэн.

### **4.Сорговь уурхайн ойролцоо байрших онцлох амьтдын тухай**

#### **4.1 Хулан**

Сорговь уурхайн зүүн, зүүн урд хэсгээр илүү их тархацтай. Цувираагийн хэсгийн толгод, Хөвсгөл сум явах зам ихээр таардаг.

Биеийн урт 220 см, мундаагаараа 137 см өндөр, сүүл 49 см, жин 200 кг хүрнэ. Гэрийн адуутай харьцуулахад, толгой том, чих урт, сүүл зөвхөн үзүүрийн хэсэгтээ шингэхэн богино хялгастай. Ерөнхий зүс хул. Зун улаавтар, өвөл цайвар хул. Мундаанаас сүүлний уг хүртэл зоо нуруу дагуу нарийхан хүрэн бор судалтай. Дэл сүүлний хялгас бараан.

Дэлхийн нийт хулангийн сүргийн 60-70 хувь Монголд байдаг бөгөөд Хулангийн нийт тархалтын 67 хувь Дорноговь аймагт байдаг гэж үздэг байна. Монгол улс агнахыг 1953 оноос хуулиар хориглож, Монгол улсын засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын ховор амьтны хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номд оруулсан.

#### **4.2 Хар сүүлт**

Биеийн урт 97--118 см, сэрвээгээрээ 61-70 см өндөр, жин 20-30 кг. Сүүл 16-24 см, хар, хар хүрэн өнгөтэй. Тангийн дээд зах сүүлний уг хүрнэ. Зун зоо нуруу улаан шаргал, хэвэл тод цагаан, өвөл цайвар шаргал, хэвэл цагаан.

Дорноговь аймгийн нутгаар нэлэнхүй, Дундговийн өмнө хэсэг, Сүхбаатар аймгийн баруун өмнөд хэсэг, Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд цөөн тоогоор алаг цоог тархсан. Уулсын бэлийн хялганат, хялгана-баглуурт, сайр садарга бүхий дагжуур хөрст хэвгий газар, загт, заг--бударганат говь, сондуул бүхий бут сөөгт цөл, хээр, хотос хоолой зэрэг орчинд байршин нутагладаг.

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтнаар бүртгэсэн. Монголд 1962 оноос хар сүүлт зээрийг үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг хуулиар хориглож, зөвхөн иргэдийн хүнсний хэрэгцээнд IX сарны 15--аас X сарын 30 хүртэл хугацаанд түр агнахаар тогтоож, 1965 оноос агнахыг бүрмөсөн хориглож, Монгол улсын улаан номд оруулан, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн хар сүүлт зээр тархсан нутгийг улсын тусгай хамгаалалттай газар болгожээ.

#### **4.3 Цагаан зээр**

Сорговь уурхайн ойролцоо 2020 оны 10-р сараас хойш ихээр байршин амьдарч байгаа. Хул шаргал зүстэй, богино сүүлтэй, цагаан шаргал танатай, шаргачин нь эвэргүй, ооно нь арагшаа тахийж үзүүр нь дотогш эргэсэн хоёр шорон эвэртэй. Биеийн урт 100-145 см, сэрвээний өндөр 54-58 см, биеийн жин ооно 40-45 кг, шаргачин 30-32 кг, оонын эврийн урт 180-200мм байдаг. Хиаг, хялгана, агь, дэрс, хазаар өвс, үет ургамалжилтай хялганат хээрт идээшин амьдарна.

Манай оронд цагаан зээрийг авто хөсгөөр хөөх, шөнө гэрэлтүүлэн хорих зэрэг аргаар агнахыг хориглодог юм.Мөн энэ гөрөөсний тоо цөөрч, байршил нутаг нь хомсдож байгааг харгалзан 1980 оноос эхлэн агнуурын нөөцтэй болтол нь агнахыг хоригложээ.



Зураг 2. Төслийн талбайн ойр орчим тааралдсан хар сүүлт



Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 2023 он  
Зураг 3. Төслийн талбайн ойр орчим тааралдсан Цагаан зээр




Зураг 4. Ан амьтад зориулсан мэдрэгчтэй худгийн камерын бичлэг





Зураг 6. Судалгаа хийсэн замын маршрут



№	Нэр	Координат		Тоо ширхэг	Нийт
1	Хулан	43° 41'40.161" N	109° 1'28.547" E	1	11
		43° 39'27.120" N	109° 6'17.197" E	4	
		43° 49'10.038" N	109° 7'12.262" E	6	
2	Хар сүүлт	43° 4' 9.051" N	109° 3'59.321" E	2	35
		43° 41'52.917" N	109° 7'40.905" E	11	
		43° 41'41.439" N	109° 13'50.904" E	7	
		43° 44'55.577" N	109° 14'46.600" E	12	
		43° 44'55.577" N	109° 9'54.202" E	15	
3	Хар хэрээ	43° 41'23.592" N	109° 6'34.479" E	1	1

**Дүгнэлт:**

Төслийн талбайн баруун урд зүгээс зүйн хойд зүг хүртэл нийт 54 км зам явж ан амьтадын судалгаа хийсэн. Тус судалгаанд Хулан, Харсүүлт, Хархэрээ, хээрийн бор Болжмор зэрэг амьтад байна. Үүнд хулан уурхайн баруун урд, урд, зүйн хойд цэгт нийт 11 тоогоор, Хар сүүлт төслийн талбайн урд, зүйн урд, зүйн хойн зүгт 35 тоогоор нийт 9 цэгт ажиглагдлаа. Мөн ан амьтад зориулсан мэдрэгчтэй худгийн камерт Туулай, Болжмор, Хэрээ, Цагаан зээр, Хар сүүлт, Хулан зэрэг ан амьтад ус ууж буй нь камерын бичлэгт хадгалагдсан байна.



## 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ, НӨХӨН ОЛГОВРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих орчны оршин суугчдын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тооцох шаардлагагүй болно. (БОННУ-2018)

“Сора Интернэйшнл” ХХК-ийн “Сорговь” нүүрсний уурхайн 2023 оны уурхайн бүтээн байгуулалтын явцад төслийн талбайн орчны бүс нутагт 5 км-ийн радиус дотор малчин айл өрх, суурийн газар байхгүй тул 202 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох талаарх арга хэмжээг төлөвлөөгүй.

## 9. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс 2013 онд археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг хийж, уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд 4 булш, 1 чулуун байгууламж, нийт 5 тооны дурсгал илрүүлэн баримтжуулсан. Энд байгаа булш, чулуун байгууламжууд нь төслийн бүтээн байгуулалт, уурхайн ухалгад өртөхөөргүй байрлалтай байна. Гэсэн хэдий ч цаашид уурхайн үйл ажиллагаанд өртөхөөс сэргийлэх зорилгоор 2020 онд хамгаалах ажил хийгдсэн. Тиймээс төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлээгүй.

## 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Хүснэгт 7.

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Биелэлт
1.	ШТМ хөрс бохирдохоос сэргийлэх, хяналт тавих, шаардлагатай цэгүүдэд асгаралтын иж бүрдэл байршуулах	Түлш, тосны талбай, засварын шоп	3	Асгаралтын иж бүрдлийг шаардлагатай 3 цэгт байршуулсан.
2.	ШТМ бохирдсон хөрсийг төвлөрүүлэх саармагжуулах	Уурхайн талбайд	1	Бохирдсон хөрсийг саармагжуулах талбайд тээвэрлэж саармагжуулах ажил хийгдэг.

Зураг 13. /Химийн бодисоос сэргийлэлт/



Зураг 14. /Хөрс саармагжуулах талбайн төлөвлөлт/



Зураг 15. /Бохирдсон хөрс саармагжуулах талбай/



### 10.1. Химийн бодисын ашиглалт хэрэглээний сургалт

Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэмжээнд ашиглагдаж байгаа химийн агууламж бүхий бодис, материал, хог хаягдлыг бүртгэлжүүлж мэдээллийн сан бүрдүүлсэн. Химийн бодисын агууламж бүхий бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтанд холбогдох хууль болон дотоод журмын дагуу хянаж сургалт, танилцуулга нийт ажилчдад танилцуулсан.

Хүснэгт 8.

№	Сургалт	Сургалт авах шаардлагатай субъект	Биелэлт
1.	Аюултай болон хортой бодис	Бодистой ажилладаг бүх хүн	Шинэ ажилтаны зааварчилгаанд тусгаж танилцуулдаг.
2.	Бусад химийн бодис	Хамааралтай албан хаагч	
3.	Химийн бодис асгарсан үед авах арга хэмжээ	Нийт ажилчид	

## 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ

### 11.1. Зорилго

Монгол улсын ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартуудыг мөрдөж уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх шууд болон дам нөлөөллийг боломжит хамгийн бага түвшинд хүргэх. Энэ зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажилласан.

- Аюултай хог хаягдал үүсэхээс зайлсхийх, аюултай хог хаягдлыг саармагжуулж урт хугацаанд байгаль орчинд халгүй хэлбэрээр зайлуулах.
- Үйлдвэрээс гарах хог хаягдлын хэмжээг багасгах зорилгоор эх үүсвэр дээр нь ангилан ялгалт хийх.
- Орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор хог хаягдлыг ил хаяхгүй байх, тусгай тэмдэглэгээ бүхий хогийн саванд цуглуулах, хуваарьт цэвэрлэгээ хийх, хог тээвэрлэх зэрэг ажиллагааг уурхайн хэмжээнд мөрдөх тусгай журмаар хэрэгжүүлэх.
- Эргүүлэн ашиглах боломжтой хаягдлыг 100 хувь дахин боловсруулах.
- Хог хаягдлын гарц, урсгал болон ангилан ялгалтыг хянах зорилгоор хог хаягдлын мэдээ, бүртгэл, баримтжуулалт хөтлөх, мэдээллийн сан үүсгэх.
- Хаягдал усны чанар болон, уурхайд ашиглагддаг материал, хаягдлын хорын чанарт хяналт тавих.

Хүснэгт 9.

<b>Монгол улсын хууль</b>	
Монгол улсын Үндсэн хууль	
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай. /Шинэчилсэн найруулга/	
Байгаль орчныг хамгаалах тухай	
Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/	
<b>Стандарт</b>	
MNS 5924-2008. Нүхэн жорлон, угаадасны нүх.Техникийн шаардлага	
MNS 5975-2009. Бохир усан дахь өөх тос баригч төхөөрөмж.Техникийн ерөнхий шаардлага	
MNS 6230-2010. Бохир ус зайлуулах цэг тогтоох.Ерөнхий шаардлага	
MNS 4288-1995 Бохир усны цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих ерөнхий шаардлага.	
MNS 4943-2011 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага	
<b>Сайдын тушаал (журам)</b>	
Аюултай хог хаягдлын хадгалалт, устгалын бүртгэл хөтлөх, мэдээ гаргах заавар	БО-ны сайдын 2003/07/01 № 127 тушаал
Хог хаягдал булаах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булаах, устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тухай журам	БО-ны сайдын 2006/12/05 № 404 тушаал
Аюултай хог хаягдлын ангилал, зэрэглэл батлах тухай-324	БО-ны сайд, ЭМ-ийн сайд, БСШУ-ны сайдын 2006/09/29 № 324/318/336

### 11.2. Хог хаягдлын эх үүсвэрт тавигдах стандарт шаардлага

Хог хаягдлын эх үүсвэрт ажилчдын хотхон, засвар, техник үйлчилгээний газар, ажлын байр, хүнд машин механизмын зогсоолын талбай, нүүрс ачилт борлуулалтын талбай, харуулын байр, болон хог хаягдал тогтмол үүсдэг бусад объектуудыг хамруулан ойлгоно. Эдгээрээс үүсэх хаягдлын төрөл, гарц, хэмжээтэй уялдуулан хог хаягдлыг цуглуулах, бохирдлыг хяналтанд авах зориулалтын хэрэгсэл, сав, баглааг байршуулах, нөөцийг бэлэн байлгах зэрэгт хяналт тавьж ажилласан.

### 11.3.ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 10.

№	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1.	Аюултай хог хаягдлыг байгаль орчинд халгүй хэлбэрээр зайлуулах.	Бүх хэлтэс, нэгж, гэрээт компаниуд	Мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж гэрээний дагуу хог хаягдлыг тухай бүрд зайлуулан устгалд оруулна.	Эмнэлэгийн хог хаягдлыг Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан нийлүүлэн устгуулж байна. Уурхайд тусгай тэмдэглэгээ бүхий саванд хадгалдаг.
1.	Орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор хог хаягдлыг ил хаяхгүй байх, тусгай тэмдэглэгээ бүхий хогийн саванд цуглуулах, хуваарьт цэвэрлэгээ хийх	Бүх хэлтэс, нэгж, гэрээт компаниуд	Төслийн талбайд их цэвэрлэгээ зохион байгуулах	Их цэвэрлэгээний хуваарь гаргаж сард 2 удаа бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулдаг.
2.	Усны савыг ангилан ялгаж боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Төслийн хэмжээнд	Зөвшөөрөлтэй ААН-тэй хамтран ажиллах	Хуванцар савыг ангилан ялгаж үйлдвэрт 2 удаа нийлүүлсэн.
3.	Хог хаягдал түр хадгалах байгууламж байгуулах	Уурхай	Хог хаягдлыг төрөлжүүлэн хадгалах	Хог хаягдлыг ангилан хадгалах түр цэг кемп аж ахуй болон засварын хэсэгт байгуулсан.
4.	Энгийн хог хаягдын гэрээ хөвсгөл сумтай байгуулах шаардагдах мөнгөн хөрөнгийг орон нутгийн төсөвт төлөх	Уурхай үйл ажиллагаанаас гарч буй энгийн хог хаягдал	Хог хаягдлыг төлбөр тооцоо төлсөн баримт	

Зураг 16. /Хог хаягдлын ангилалт хийх цэг/



Зураг 17. /Их цэвэрлэгээ/





Зураг 18. /хуванцаар саваа түр зурлуулах тор/



11.4 Мэргэжлийн байгууллагаар хийгдэх ажлууд

№	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх	Төслийн талбайд	Мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж хамтран ажиллах	Энгүй таван эрдэнэ ХХК ажлыг гүйцэтгэсэн.
2	Орчны хяналт шинжилгээний багажнуудыг Стандарт хэмжилзүйн газраар баталгаажуулах	Мониторингийн багаж хэрэгсэл	Стандарт хэмжилзүйн газраар багаж баталгаажуулах	Жилдээ 1 удаа Америк улсад очиж стандарт хэмжилзүйн баталгаажуулалт хийлгэдэг.



## 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

### 12.1.Зорилго

Уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шинжлэх ухааны үндэслэлтэй аргачлал, стандартаар хянах зорилготой. Энэхүү хяналтын үр дүнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоосноор түүнийг эдийн засгийн хэмнэлттэй арилгах арга хэмжээг оновчтой тодорхойлох юм. Энэ зорилгын хүрээнд хөрс-ургамал, агаар, усан орчинд үзүүлэх нөлөөллийг хянахад хэмжилтийн багаж төхөөрөмж ашиглах, тэдгээрийн калибраци, тохиргоог хангах, дээж авах зааварчилгаа болон лабораторид дээж хүргэн шинжлүүлэх горимыг мөрдүүлэх, усны хэрэглээ, хог хаягдлын гарц урсгалын хяналтыг бүртгэлжүүлэх зэрэг зорилтыг хэрэгжүүлсэн.

### 12.2. Агаарын чанарын хяналт

Хүснэгт 11.

№	Хяналтын үзүүлэлтүүд	Байршил	Биелэлт
1.	Тоосны агууламж: PM10, PM2.5	Уурхай	Уурхайн шаарлагатай агаарын мониторингийн цэгүүдэд тоосонцорын хэмжилт хийдэг
2.	Цаг агаар уурын үзүүлэлт хэмжих	Төслийн талбай	Цаг агаарын мэдээг тухай бүрт нь нийт ажилчдад танилцуулж, гадаа орчны температурыг тогтмол хэмждэг.

### 12.3.Усан орчны хяналт

Хүснэгт 12.

№	Хяналтын үзүүлэлтүүд	Байршил	Биелэлт
1.	Хими, физик	Нөлөөллийн бүсийн худгууд	Усны чанарын хяналт шинжилгээ тогтсон хугацаанд УБ хот инженер геодези ХХК-ны лабораторт шинжлүүлсэн. -Ханлаб ХХК бохир усны шинжилгээ хийлгэсэн.
2.	Бактериологи	Унд ахуйн ус	
		Кемп аж ахуй бохир ус	

### 12.4.Ургамлан бүрхэвчийн хяналт

Хүснэгт 13

№	Арга хэмжээ	Байршил	Биелэлт
1.	Ургамлан нөмрөгийн өсөлт хөгжилт, зүйлийн бүрдэл, ургацын дээж, хөрсний чийг, температур, хөрсний тогтвортой байдал	Төслийн талбайн нөлөөллийн бүс	Ургамлын мониторинг 1 удаа хийгдсэн.
2.	Бэлчээрийн хамтын шинжилгээний баг бэлчээрийн ажиглалт хийх	Хөвсгөл сумын Жавхлант баг	
3.	Модны өсөлт хөгжилтийн ажиглалт судалгаа хийх	Төслийн талбай	2020 онд тариалсан модны өсөлт хөгжилт амьдрах чадварт хяналт хийсэн. Говийн нөхцөлд ургах боломжтой 2 төрлийн мод тариалсан. Цаашид ургалт, дасан зохицох чадвар сайн байгаа модыг сонгон тариалах.
4.	Бэлчээрийн хамтын шинжилгээний баг бэлчээрийн ажиглалт хийх	Хөвсгөл сумын Жавхлант багийн нутаг	

## Үндэслэл

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөллийг багасгаж хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн үр ашигтай менежментийн арга хэмжээг байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхэд оршино.

Дээрх ажлын хүрээнд 2023 оны 09-р сарын 30-ний өдөр Ургамал ажиглалтын судалгааг Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Жавхлант багийн Сорговь уурхайн төслийн ойр орчмын талбайд хийж гүйцэтгэлээ.

## Хөрсний хэв шинж:

Говийн хөрсний их мужийн цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг. Хур тунадас ховор, эрс тэс гандуу уур амьсгалтай, өвс ургамал тарчиг сийрэг энэ талбай нь говийн бор хөрстэй.

**Ургамлын судалгааны ажлын явцад:** Хайлаас, Заг мод Үетэн ургамал, Таана, Хөмүүл, Төлчдүү боролж, Говийн хялгана, Шар бээрмэг, Амманы сэдэргэнэ, Харгана, Бударгана, Хармаг, Баглуур, Шарилж, Хагд өвс, Дагуур хүж өвс гэх мэт зүйлийн ургамалан бүрхэвч тааралдав.

### Ургамлын нэр: Хармаг



### Ургамлын нэр: Шар бээрмэг/ *Limonium aureum* /

**Ургамлын тархац:** Дорноговь, Өмнөговь, Говь Алтай, Баянхонгор, Ховд аймгийн нутгаар ургадаг

Хармаг ургамал нь Дорноговь аймгийн нутгийн нуур тойрмын зах, элсэн хөрстэй хотгор, гуу жалга, хужир марзтай газарт хэвтээ ишнээс олон салаалж ургасан 50-80 см өндөр сөөгт нэг дор 3-7 ширхгээр багцлан ургасан хөхөвтөр хүрэн, хүрэн өнгөтэй, зөөлөн чихэрлэг жимсийг хармаг гэнэ. Хармаг нь 7 дугаар сарын эх, дунд үеэр цэцэглэж 8. 9 дүгээр сард боловсорч гүйцнэ. Хармаг жимс С витамин, органик хүчил, чихэрлэг бодисоор баялаг. Түүнийг говь нутгийнхан түүж чанамал, ундаа, амтат дарс хийж ашигладаг.

**Ургамлын тархац:** Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Говь Алтай, Дорнод Говь, Алашааны Говь. Дундговьд: Өмнө талын сумдын нутагт элбэг тохиолдоно.





**Ургах нөхцөл:** Цөл ба цөлөрхөг хээрийн бүсэд хайрга чулуутай толгод, түүний бэл хормой, тэгш тал, цайдам, тойром, сайраар ургана.

**Ач холбогдол:** Мал иддэг бэлчээрийн болон гоёл чимэглэлийн ургамал.

**Ургамлын нэр:** Хөмүүл /*Allium mongolicum*/

**Ургамлын тархалт:** Хангайн өмнөд хэсэг, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор болон Олон нуурын хөндий, Говь Алтай, Дорнод Говь, Алтайн өвөр говьд. Дундговьд: Өмнөд, баруун, зүүн урд, төвийн сумдын нутагт тохиолдоно.



**Хөмүүл нь** *Allium mongolicum* буюу Монгол сонгино гэдэг нэртэй, Монгол нутгийн унаган ургамал юм. Сонгино, сармисны л төрлийн ургамал.

**Харгана**

**Шарилж, хагд өвс**



Баглуур



Уурхайн баруун урд талд



Цувираагийн сайр



1x1 м трансекц



Ургамлын өндөр үзүүлэлт



Хайлаас мод

Заг мод



Цувираагийн сайр дагаж Хайлаас мод цөөн тоогоор ургасан. Хэв шинжийн хувьд 8-12 метр өндөр, ишний голч 35-40 см, навч 3-5м урттай.



Заг мод нь уурхайн баруун урд хэсгээр давамгайлсан ургасан тухайн орчны Нэг хэсэг баянбүрдэрхүү газрыг төлөөлж байна. Ургалтын өндөр 2,5-3 м орчим өндөр ургасан.

## Дүгнэлт

Ургамал ажиглалтын дүнд ургамалан бүрхэвчийн эзлэх хувь бага, Ургалтын хувьд зарим ургамал бүрэн гүйцэт боловсроогүй Энэ жилийн хувьд бороо ус бага орсонтой холбоотойгоор нэг наст ургамал цөөн ургасан

Уурхайн ойр орчмын нутаг дэвсгэрийн хувьд Хайлаас, Заг мод Үетэн ургамал, Таана, Хөмүүл, Төлчдүү боролж, Говийн хялгана, Шар бээрмэг, Амманы сэдэргэнэ, Харгана, Бударгана, Хармаг, Баглуур, Шарилж, Хагд өвс, Дагуур хүж өвс гэх мэт зүйлийн ургамалан бүрхэвч тааралдсан.

Уурхайн орчмын цөлжилтийн эсрэг тэмцэж байгаа гол хүчин зүйл Заг мод ихээхэн нөлөөлж байна

## 12.5. Хөрсөн бүрхэвчийн хяналт

Хүснэгт 14

№	Хяналтын үзүүлэлтүүд	Байршил	Биелэлт
1.	Хими, физик	Шимт хөрсний овоолго	-Хөрсний чанарын хяналт шинжилгээ Инженер геофизи ХХК-р гүйцэтгүүлсэн. -Ханлаб ХХК-д бохир усны шинжилгээ гүйцэтгүүлсэн.
2.	Хими, физик, бохирдуулагч	Уурхайн объектууд	
3.	Газар ашиглалтийн хяналт	Хөрсний хяналтын цэгүүд	
4.	Газрын төлөв байдал	Лицензийн талбайн хүрээ	
		Төслийн талбай	

Зураг 18. /Агаарын чанарын хэмжилт/



Зураг 19./Усны чанарын хэмжилт/



Зураг 20. /Хөрсний чанарын хэмжилт/



### 13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Байгаль орчны чиглэлээр хийгдсэн мэргэжлийн байгууллагын үзлэг шалгалт, аудитын үр дүн болон байгаль орчны зөрчил гарсан тохиолдлыг бүртгэж, үнэлж, засаж залруулах, сэргийлэх арга хэмжээг авч, шаардлагатай бүх талуудад тайлагнах арга хэмжээ авч ажилласан.

Хүснэгт 15.

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Биелэлт
1.	Бичиг баримтын бүрдүүлэлтийг хангах	2023 онд	“Сора Интернэшнл” ХХК	Монгол улсын хуулийн дагуу бичиг баримтын бүрдлийг ханган ажиллаж байна.
2.	Хууль эрх зүйн, дүрэм журмын дагуу явагдаж байгаа эсэхийг хянаж, засаж залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	2023 онд	“Сора Интернэшнл” ХХК	Улирал бүр дотоод хяналт шалгалт аудит хэлтэс тус бүрт хийж үл нийцэл, зөрчлийг арилгуулах хариу арга хэмжээ авах ажлыг хэрэгжүүлдэг.
3.	БОХМТ-ийг тайлагнах хурлыг зохион байгуулахад оролцох	2023 онд	“Сора Интернэшнл” ХХК	Ковид-19 вирусын халдварт цар тахлаас шалтгаалан олон нийтэд танилцуулах боломжгүй байсан.Тайлангийн биелэлт танилцуулах хүсэлт Хөвсгөл сумын ЗДТГ-т илгээсэн.
4.	Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагтай хамтран ажиллах	2023 онд	“Сора Интернэшнл” ХХК	Байгаль орчны чиглэлээр орон нутгаас албан шаардлага ирүүлсэн тохиолдол бүрт хамтран ажилласан.

#### 13.1. Сургалт

Байгаль орчны танин мэдэхүйн сургалтыг тогтмол явуулах, байгаль орчныг хамгаалах сөрөг нөлөөлөлийг багасгах талаар ажилчдад санамж, зөвөлгөө өгөх шинээр ирсэн ажилчдад болон нийт ажилчдад сургалтыг тасралтгүй явуулдаг. Мөн ажилчид ихээр цугларах цэгүүдэд байгаль орчны танин мэдэхүйн зөвөлгөө, санамж бичгүүдийг байрлуулсан.

##### 13.1.1. Сургалтын хуваарь

Хүснэгт 16.

№	Сургалтын нэр	Агуулга	Биелэлт
1.	Байгаль орчны ерөнхий зааварчилгаа	Шинээр уурхайд ажиллахаар ирсэн ажилтанд уурхайн үйл ажиллагааны явцад учирч болох сөрөг нөлөөлөлийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгөх	Шинэ ажилтаны сургалт нийт 25 удаа орж 311 хүн хамруулсан.
2.	Хог хаягдлын менежмент	Уурхайн хэмжээнд гарч байгаа хог хаягдлын урсгал сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээг танилцуулах	Хог хаягдал ангилан ялгах тухай, компаний дотоод хог хаягдлын журам танилцуулсан.
3.	Асгаралтын менежмент	Асгаралтын журам танилцуулах	Асгаралтын журмыг наряд зааварчилгаагаар тогтмол танилцуулдаг.
4.	ХАЛМ	Химийн бодисын хэрэглээ мөн аюулгүй ажиллагааны талаар мэдээлэл өгөх	ХАЛМ-н тухай сургалт 2 удаа орсон.

4.	Усны менежмент	Усны зөв, зохистой хэрэглээ мөн дэлхийн усны өдөр мэдээ мэдээлэл өгөх	Дэлхийн усны өдөрт зориулан Усны зөв зохистой хэрэглээ сэдэвээр сургалт орсон.
5.	Хөрсний менежмент	Хөрсний бохирдол, сөрөг нөлөөлөлийг багасгах урьдчилан сэргийлэх	Шимт хөрс хуулах, газар хөндөх тухай журмыг танилцуулан өнгөн хөрсний ач холбогдлыг нийт ажилчдад таниулах ажил хийгдсэн.
